| № | Төслийн нэр, дугаар | | | Төсөл хэрэгжүүлэгч болон хамтран хэрэгжүүлэгч байгууллага | Төслийн зорилго | Төслийн үндэслэл, хэлбэр | Төслийн хүрээнд хийж гүйцэтгэсэн ажил, үр дүн, тайлан | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Төслийн нэр /Монгол/ | Төслийн нэр /Англи/ | Төслийн дугаар | | | | | |
| 1 | Ерөнхий боловсролын сургуулийн эмч нарыг Өсвөр үеийн эрүүл мэндийн чиглэлээр чадавхжуулах сургалт | Capacity building training for secondary school doctors in Adolescent Health | | ЭМХТ | Ерөнхий боловсролын сургуулийн эмч нарт өсвөр үеийн эрүүл мэнд, нийгмийн асуудал, хөгжлийг дэмжих чиглэлээр мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтыг зохион байгуулах. | Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ), Нэгдсэн үндэсний байгууллагын Хүүхдийн сан (НҮБ-ын ХС)-аас өсвөр насныхан эрүүл саруул өсч хөгжихөд насанд нь тохирсон бэлгийн цогц боловсрол, амьдралын ур чадварыг хөгжүүлэх боломж, хүлээн зөвшөөрөгдсөн, тэгш хүртээмжтэй, зохистой, үр дүнтэй эрүүл мэндийн үйлчилгээ, аюулгүй бөгөөд дэмжлэг үзүүлэх орчин шаардлагатай болохыг зөвлөмж болгосон. Иймд ерөнхий боловсролын сургуулийн эмч нарт өсвөр үеийн эрүүл мэнд, нийгмийн асуудал, хөгжлийг дэмжих чиглэлээр мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтыг зохион байгуулах шаардлагатай байна. Учир нь өсвөр насныхны өвөрмөц хэрэгцээ, эрх ашгийг хангахад эрүүл байх, эрүүл мэндээ сайжруулахдаа ухамсартайгаар оролцох боломжийг өргөжүүлэх нь чухал үүрэг гүйцэтгэдэг. | 1.“Ерөнхий боловсролын сургуулийн эмч нарыг Өсвөр үеийн эрүүл мэндийн чиглэлээр чадавхжуулах сургалт зохион байгуулах аргачлал удирдамж”-ийн хэрэгжилтийг хангах зорилгоор 2023 оны 04-р сарын 24-28 өдрүүдэд 1-р ээлж, 2023 оны 05-р сарын 08-12-ны өдрүүдэд 2-р ээлжийн сургалтыг ерөнхий боловсролын сургуулийн нийт 200 гаруй эмч, багш нарт тус тус зохион байгуулсан. 2. Өсвөр үеийн эрүүл мэнд, нийгмийн асуудал, хөгжлийг дэмжих чиглэлээр мэргэжлийн баримжаа олгох, өөрөө бие даан суралцах цахим сургалтын модуль боловсруулах зорилтын хүрээнд дараах 15 видео хичээлүүдийг бэлтгэсэн. | 100% |
| 2 | Орон нутагт зохион байгуулах хүүхдийн өвчний цогц менежмент-I үе шат | Local IMCI training | 202 & Access to ECD & primary education | ЭМХТ | Орон нутгийн ЭМГ-аас ирүүлсэн хүсэлтийг үндэслэн ХӨЦМ-ийн шинэчилсэн модулийн дагуу орон нутагт сургалт зохион байгуулснаар орон нутгийн хүүхдэд тусламж үзүүлдэг эмч мэргэжилтний ур чадварыг сайжруулах зорилготой. | ДЭМБ-аас ХӨЦМ-ийн сургалтын хөтөлбөрийг 2007, 2014, 2019 онуудад баяжуулан шимэгч хорхойтох өвчин, шуугиантай амьсгал, төрсний дараа 7 хоног хүртэлх нярайн менежмент, ХДХВ-ийн халдварын талаар шинэ хөтөлбөр оруулж, антибиотикийн тун сонголт, суулгалт, хүнд тураал зэрэг өвчний эмчилгээ, хоолны зөвлөмжийг шинэчлэн, дархлаажуулалтын шинэ товлолыг багтаасан. Мөн 2018 онд нярайн эрт үеийн менежментийг оруулан нярайн тусгай модуль гаргасан. Тэдгээр шинэчлэлийг орон нутгийн хүүхдэд тусламж үзүүлдэг эмч, эмнэлгийн мэргэжилтэнд таниулах, тэдний ур чадварыг дээшлүүлэхийг зорьсон. | Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирлын баталсан удирдамжийн дагуу НҮБ-ийн Хүүхдийн сангийн санхүүжилтээр “Хүүхдийн өвчний цогц менежмент” эмнэлзүйн сургалтыг Төв, Орхон, Сэлэнгэ, Булган, Дундговь, Дорноговь, Говьсүмбэр, Дархан, Архангай аймгуудад тус бүр 5 хоногийн хугацаанд зохион байгуулсан.Сургалтыг ХӨЦМ-ийн үндэсний сургагч багш нар удирдан явуулсан ба нийт 200 эмч сургалтад хамрагдсан. Сургалт нь онол, дадлага хослон явагдсан ба суралцагч бүрт ХӨЦМ-ийн 7 модуль ном, 2 гарын авлага олгосон. | 100% |
| 3 | Хүүхдэд үзүүлэх ЭМ-ийн анхан шатны тусламж үйлчилгээний сурах бичгийг орчуулах ажил | POCKET BOOK OF Primary health care for children and Adolescents Translation | 202 & Access to ECD & primary education | ЭМХТ | Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх эмч нарт зориулсан сурах бичгийг орчуулж, өдөр тутамдаа ашигласнаар хүүхэд, өсвөр үеийнхэнд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээ, эмийн зохистой хэрэглээ сайжирна. | Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх эмч нарт зориулсан сурах бичгийг орчуулж, өдөр тутамдаа ашигласнаар хүүхэд, өсвөр үеийнхэнд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээ, эмийн зохистой хэрэглээ сайжирна. | Хүүхдийн эрүүл мэндийг дэмжих, өвчнөөс сэргийлэх, оношлох, эмчлэх асуудлыг цогцоор багтаасан 900 гаруй хуудас бүхий сурах бичиг тул англи хэлнээс монгол хэл рүү 13 эмч, мэргэжилтэн орчуулж 5 мэргэжилтэн редактор хийсэн. | 100% |
| 4 | Олон нийтэд түшиглэсэн хүүхдийн тусламж үйлчилгээ сургалтын сургагч багш бэлтгэх | 101 Child Survival and Development | 101 MNCH, Adolescent Health | ЭМХТ | “Олон нийтийн эрүүл мэндийн ажилтан”-г амьдарч байгаа хүрээний бүрэн дунд боловсролтой иргэдээс бэлтгэх | Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг бэхжүүлэхэд, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд учирч байгаа тулгамдсан асуудлуудыг хамтран шийдвэрлэхэд олон нийтийг татан оролцуулсан бусад улс орны туршлага болон НҮБ-ийн хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр нийслэлийн Баянзүрх дүүрэг, Баянхонгор, Говь-Алтай, Завхан аймагт хэрэгжүүлсэн “Олон нийтийн эрүүл мэндийн ажилтан”-ы сайн туршлагыг хэрэгжүүлэх талаар Дундговь аймгийн ЗДТГ”- аас ирүүлсэн хүсэлтийг үндэслэн тус аймагт “Олон нийтийн эрүүл мэндийн ажилтан” бэлтгэх сургагч багшийн сургалт зохион байгуулах, олон нийтийн эрүүл мэндийн ажилтанг богино хугацаанд бэлтгэж, эрүүл мэндийн байгууллагуудад ажиллуулж эхлүүлэхэд энэхүү үйл ажиллагаа чиглэгдэнэ. | 2023.08.25-27-ны өдрүүдэд ОНЭМА бэлтгэх сургагч багшийн сургалтыг зохион байгуулсан ба Дундговь аймгийн сумдын эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн нийт 20 сургагч багш бэлтгэгдсэн. | 100% |
| 5 | ШҮДНИЙ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТАЛААРХ СУРГАЛТЫН МАТЕРИАЛ БЭЛТГЭХ | /PREPARATION TRAINING MATERIALS OF QUALITY AND SAFETY OF DENTAL CARE | 101. Эх, хүүхэд, өсвөр үеийн эрүүл мэнд | ЭМХТ | Шүдний тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын стандарт шинэчлэгдэн боловсруулж байгаатай холбогдуулан тус шинэчлэгдсэн стандартыг эмч, мэргэжилтнүүдэд таниулах үүний үр дүнд уг стандартыг өдөр тутмын ажилдаа хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх | Хүний хөгжлийн хамгийн эрчимтэй, чухал үе болох бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих нь тэдэнд оруулж буй хамгийн ухаалаг хөрөнгө оруулалт болох нь олон судалгаагаар нотлогдсон байдаг. Иймд бага насны хүүхдийн эрүүл мэнд, хоол тэжээл, асран хамгаалал, боловсролын хөгжлийг нэгдмэл хандлага, арга зүйгээр дэмжих ажиллахыг олон улсын хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд зөвлөмж болгосон байдаг. Иймээс эрүүл мэндийн анхан шатны байгууллагад өдөр тутам ашигладаг “Хүүхдийн өвчний цогц менежмент” сургалтын модулд бага насны хүүхдийн хөгжлийн асуудлыг нэгтгэх шаардлагатай байна. | Уг төслийн хүрээнд БНХХ-ийг дэмжих тусламж үйлчилгээний сургалтын сургагч багшийн гарын авлага, сургалтын оролцогчийн гарын авлага, эрүүл мэндийн байгууллагад БНХХ-ийн үйлчилгээнд дэмжлэгт хяналт хийх нийт 3 гарын авлагыг орчуулж бэлтгэсэн. Претест хийх сургалтыг 12 сарын 20-22-ны өдрүүдэд НЭМГ-ын харьяа Хүүхдийн сэргээн засах Хантуул төвд зохион байгуулсан. | 100% |